

ХАВСРАЛТ.

ТЕЗ-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСВИЙН САНАЛЫН МАЯГТ БӨГЛӨХ ЗААВАР

- 1 ТЕЗ-ийн Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан үр дүнд суурилсан төсвийн саналын маягт**
 - 1.1 Ерөнхий мэдээлэл
 - 1.2 ТЕЗ-ийн эрхлэх үндсэн асуудлын хүрээ
 - 1.3 Үндэсний болон салбарын дунд хугацааны бодлогын баримт бичиг болон хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан зорилго, зорилт болон ТЕЗ-ийн хүрэх үр дүнгийн уялдаа
 - 1.4 ТЕЗ-ийн хүрэх үр дүн, түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, гарц, тэдгээрийн шалгуур үзүүлэлт
 - 1.5 ТЕЗ-ын хүрэх үр дүнг хангахад чиглэсэн стратеги
 - 1.6 ТЕЗ-ийн Төсвийн санал
 - 1.6.1 2023 оны төсвийн төсөл
 - 1.6.2 ТЕЗ-ийн дунд хугацааны төсвийн санал
 - 1.7 ТЕЗ-ийн хүрэх үр дүнгийн ХШҮ-ний төлөвлөгөө
- 2 ТЕЗ-ийн хүрэх үр дүн, түүнийг хангахад чиглэсэн хөтөлбөрийн хүрэх үр дүн тодорхойлох ажлын хүснэгт 1 бөглөх заавар**
- 3 ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсвийн суурь тооцооны ажлын хүснэгт 2 бөглөх заавар**

1. ТЕЗ-ийн Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан үр дүнд суурилсан төсвийн саналын маягт

ТЕЗ-ийн Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан үр дүнд суурилсан төсвийн саналын маягт нийт 8 хүснэгтээс бүрдэнэ.

1.1 Хүснэгт1 - ТЕЗ-ийн эрхлэх үндсэн асуудлын хүрээ

1-р Хүснэгтэд Монгол улсын Засгийн газрын тухай хуульд заасан тухайн ТЕЗ-ийн эрхлэх үндсэн асуудлын хүрээ, хуулийн холбогдох зүйл, заалтыг оруулна. Тухайн эрхлэх үндсэн асуудлын хүрээтэй холбоотой хөтөлбөрийн нэрийг харгалзах мөрөнд бичнэ.

1.2 Хүснэгт2 - Үндэсний болон салбарын дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилт болон ТЕЗ-ийн хүрэх үр дүнгийн уялдаа

Энэ хэсэгт “*ТЕЗ-ийн хүрэх үр дүн, түүнийг хангахад чиглэсэн хөтөлбөрийн хүрэх үр дүнг тодорхойлох ажлын хүснэгт 1*”-д тусгасан дунд хугацааны бодлогын баримт бичгийн холбогдох заалт, түүний хэрэгжилтэд хувь нэмэр оруулах ТЕЗ-ийн хүрэх үр дүн /ТЕЗХҮД/-г харгалзах нүдэнд бөглөн тэдгээрийн уялдааг харуулна. ТЕЗ-ийн хүрэх үр дүнтэй уялдах ТХЗ-ыг харгалзах нүдэнд мөн оруулна.

1.3 Хүснэгт3 - ТЕЗ-ийн хүрэх үр дүн, түүнийг хангахад чиглэсэн хөтөлбөрийн хүрэх үр дүн, гарц, тэдгээрийн шалгуур үзүүлэлт

3-р Хүснэгтэд ТЕЗ-ийн хүрэх үр дүн, түүний шалгуур үзүүлэлтийг “*ТЕЗ-ийн хүрэх үр дүн, түүнийг хангахад чиглэсэн хөтөлбөрийн хүрэх үр дүн тодорхойлох ажлын хүснэгт 1*”-ээс авч оруулна. Үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг ШҮ гэж тэмдэглэсэн болно. ТЕЗ-ийн хүрэх үр дүнг хангахад чиглэсэн бүх хөтөлбөрийн хүрэх үр дүн, гарц тэдгээрийн шалгуур үзүүлэлтийг “*ТЕЗ-ийн хүрэх үр дүн, түүнийг хангахад чиглэсэн хөтөлбөрийн хүрэх үр дүн тодорхойлох ажлын хүснэгт 1*”-ээс мөн авч оруулна.. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, түүний гарцын шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшинг ажлын хүснэгтээс татан харгалзах нүдэнд бөглөнө. (Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг ХХҮДШҮ, гарцын шалгуур үзүүлэлтийг ГШҮ гэж тэмдэглэв).

1.4 Хүснэгт4 - ТЕЗ-ийн хүрэх үр дүнг хангахад чиглэсэн стратеги

4-р Хүснэгтэд ТЕЗ-ийн хүрэх үр дүнг хангах стратегийг “*ТЕЗ-ийн хүрэх үр дүн, түүнийг хангахад чиглэсэн хөтөлбөрийн хүрэх үр дүн тодорхойлох ажлын хүснэгт 1*”-ээс авч оруулна.

1.5 ТЕЗ-ийн Төсвийн санал

Хүснэгт5.1-д ТЕЗ-ийн хөтөлбөр тус бүрийн 2023 оны төсвийн төслийг “*ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсвийн суурь тооцооны ажлын хүснэгт 2*”-ээс авч төсвийн зардлын эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллаар зардлын кодын хамт харуулна. Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг мөн тусгана.

Хүснэгт5.2-д ТЕЗ-ийн дунд хугацааны төсвийн саналыг хэрэгжүүлэх хөтөлбөр тус бүрийн өнгөрсөн оны төсвийн төлөвлөгөө ба гүйцэтгэл, тухайн оны төсвийн төлөвлөгөө ба хүлээгдэж буй гүйцэтгэл, 2023-2025 оны төсвийн төслийг “*ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн жилийн төсвийн тооцооны ажлын хүснэгт 2*”-ээс авч бөглөнө. ТЕЗ-ийн дунд хугацааны төсвийн төслийг зардлын эдийн засгийн томсгосон ангиллаар гаргана. Тухайн хөтөлбөрийн төсвийг арга хэмжээний ангилал (шинэ, нэг удаагийн, урт хугацааны шинжтэй)-аар мөн харуулна. ТЕЗ-ийн хэрэгжүүлэх нийт хөтөлбөрийн төсвийн төслийг нэгтгэн ТЕЗ-ийн нийт төсвийг тооцож оруулна.

1.6 Хүснэгт6 - ТЕЗ-ийн хүрэх үр дүнгийн ХШ-ний төлөвлөгөө

Хүснэгт6-д ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр тус бүрийн хүрэх үр дүн, гарц, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинг харуулсан хяналт-шинжилгээ, үнэлгээний жилийн төлөвлөгөөг харуулна.

2. ТЕЗ-ийн хүрэх үр дүн, түүнийг хангахад чиглэсэн хөтөлбөрийн хүрэх үр дүнг тодорхойлох

Үндэсний болон салбарын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг хангах ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн хүрэх үр дүнг харилцан уялдаатай төлөвлөхөд энэхүү Ажлын хүснэгт 1-ийг ашиглана.

Үр дүнд суурилсан төлөвлөлтөд шатлал (үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн) хоорондын хүрэх үр дүнгийн уялдааг хангах, дээд шатны үр дүнг хангахаар дараа дараагийн шатны хүрэх үр дүнг тус тус тодорхойлно.

Үр дүн (Result) гэдэг нь тодорхой нөхцөл байдал, үйлдэл, үйл явдлын үр дүн (шалтгаан-үр дагаврын холбоо)-д үүссэн дүрсэлж эсвэл хэмжиж болохуйц **өөрчлөлт** юм. Үр дүнг уялдаа холбоо бүхий дараах 3 хэлбэрээр тодорхойлж болно. Үүнд:

- Бүтээгдэхүүн/Гарц (outputs)
- Хүрэх үр дүн (outcomes)
- Үр нөлөө (impact)

Бүтээгдэхүүн/Гарц (Output) нь орцыг ашиглаж бий болгосон хэмжиж болохуйц эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээ буюу хөтөлбөрийн арга хэмжээний үр дүн болно. Гарцыг завсрын болон эцсийн гэж ангилна.

Хүрэх үр дүн (Outcome) гэдэг нь гарцаар дамжуулан богино болон дунд хугацаанд хүрэхээр төлөвлөсөн иргэд, нийгмийн тодорхой бүлэгт зориулан бий болгосон ямар нэг үр дагавар, үр шим, ашиг тус юм. Өөрөөр хэлбэл гарцын нөлөөгөөр тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлсний дүнд гарч буй өөрчлөлт болно. Хөтөлбөрийн хүрэх үр дүн нь ТЕЗ-ийн хүрэх үр дүн, салбарын, улмаар Үндэсний хүрэх үр дүн буюу зорилго, зорилтод хувь нэмэр оруулах ёстой. Хүрэх үр дүн гэдэг нь тухайн салбарын зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд иргэд, нийгмийн тодорхой бүлэгт зориулан засгийн газар, ТЕЗ-ийн бий болгосон ашиг тус, үр шим юм

Урт хугацааны үр дүн (Impact) гэдэг нь тодорхой үр дүнд хүрснээр урт хугацаанд бий болох эдийн засаг, нийгэм, байгаль орчинд нөлөө үзүүлэхүйц өргөн цар хүрээтэй өөрчлөлтийг хэлнэ. (UN, Guideline on Programme-Based Budgeting, 2011).

Үндэсний болон салбарын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг хангахад ТЕЗ-ийн хүрэх үр дүн (ТЕЗХҮД), ТЕЗХҮД-д ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн (ТЕЗХХҮД), ТЕЗХХҮД-д хөтөлбөрийн гарц тус тус хувь нэмэр оруулах буюу дээрээс доош чиглэсэн зарчмаар үр дүнд суурилсан төлөвлөлтийг хийнэ.

2.1 ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн хүрэх үр дүн тодорхойлох

Үндэсний дунд хугацааны бодлогын баримт бичиг буюу **МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ** [Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай \(legalinfo.mn\)](http://legalinfo.mn) -д

тусгагдсан зорилго, зорилтыг хангах үүднээс ТЕЗ-ийн шийдвэрлэх асуудал, хүрэх үр дүнг тодорхойлно.

ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн хүрэх үр дүнг тодорхойлоход “Асуудал/хэрэгцээ, шалтгаан, уялдаа холбооны шинжилгээ”-г ашиглана.

“Асуудал/хэрэгцээ, шалтгаан, уялдаа холбооны шинжилгээ” нь “Эрэлтийн шинжилгээ”, “Асуудал ба шийдлийн модны шинжилгээ”, “Үр дүнгийн шатлал” гэсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй.

“Эрэлтийн шинжилгээ”-г ашиглан нийт оролцогч тал, тэдгээрийн тулгамдаж буй асуудал/хэрэгцээг тодорхойлно.

“Эрэлтийн шинжилгээ”-ний үр дүнд тулгуурлан “Асуудал ба шийдлийн модны шинжилгээ”-г хийнэ. Уг шинжилгээний үр дүнд ТЕЗ-ын шийдвэрлэх асуудал, түүний шалтгаан, шалтгааныг арилгах стратеги, стратегийг хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн шийдвэрлэх асуудал, түүний шалтгаан, тэдгээрийг шийдвэрлэх арга зам (хөтөлбөрийн стратеги), хөтөлбөрийн гарц, хүрэх үр дүнг тус тус тодорхойлно.

“Үр дүнгийн шатлал”-ийн шинжилгээгээр Үндэсний болон Салбарын хүрэх үр дүнг хангах ТЕЗ-ийн болон хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн уялдаа холбоог нягтлан тогтооно..

“Асуудал/хэрэгцээ, шалтгаан, уялдаа холбооны шинжилгээ”



Эх сурвалж: Малайз Улсын Сангийн яам, Куала Лумпур, Улсын салбар дахь хөтөлбөрийн үнэлгээ, © 1999-2009 -өөс хялбаршуулж аваа. Олон улсын үнэлгээний хөгжил ба судалгаа төв © 2014 (Малайз, Австрали)

ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн хүрэх үр дүн, гарцын шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход SMART зарчмыг баримтлах нь зүйтэй юм. Эдгээр нь хяналт, шинжилгээ үнэлгээний суурь болно.

Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт. Бодит үр дүн буюу гүйцэтгэлийг илэрхийлэх хэмжүүрийг хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт гэдэг. Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт нь үр дүнгийн хүрээнд гарч буй өөрчлөлтийг харуулах нотолгоо юм. Тоон болон чанарын шалгуур үзүүлэлт байж болно. Олон янзын шалгуур үзүүлэлтээс үр дүн, өөрчлөлтийг үнэн зөвөөр илэрхийлэх гол шалгуур үзүүлэлтийг тодорхойлох нь чухал.

Олон улсын үр дүнд суурилсан төлөвлөлтөд шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход SMART аргачлалыг өргөн ашигладаг. Энэхүү аргачлалаар шалгуур үзүүлэлт нь дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

S - Specific буюу тодорхой

M - Measurable буюу хэмжигдэхүйц

A - Achievable буюу хүрч болохуйц буюу бодитой

R - Relevant буюу хамааралтай

T - Time-bound буюу цаг хугацаатай.

Шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшинг тогтооно.

2.2 Ажлын Хүснэгт1 бөглөх заавар - ТЕЗ-ийн болон хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн тодорхойлох

Багана 1: Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээг оруулна.

Багана 2: Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл ([Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай \(legalinfo.mn\)](#)) -ээс ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлэх холбогдох заалтыг оруулна.

ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн хүрэх үр дүнг боловсруулахад “Асуудал/хэрэгцээ, шалтгаан, уялдаа холбооны шинжилгээ”-г ашиглана.

А. ТЕЗ-ийн хүрэх үр дүн

Багана 3: Эрэлтийн шинжилгээний үр дүнд тодорхойлсон ТЕЗ-ийн оролцогч талуудыг оруулна.

Оролцогч талууд: ТЕЗ-ийн хөтөлбөрийн үр шимийг хүртэгч болон тухайн хөтөлбөрт хамааралтай төрийн болон төрийн бус байгууллагууд, хувь хүн эсхүл нийгмийн бүлгүүдийг хэлнэ.

Багана 4: Мөн эрэлтийн шинжилгээг ашиглан тодорхойлсон ТЕЗ-ийн Оролцогч талуудад тулгарч буй асуудал/хэрэгцээг нотолгоо, эх сурвалжийн хамт бөглөнө.

Багана 5: Оролцогч талуудын асуудал/хэрэгцээнд суурилан “Асуудал/хэрэгцээ, шалтгаан, уялдаа холбооны шинжилгээ” ашиглан ТЕЗ-ийн шийдвэрлэх асуудал/хэрэгцээг тодорхойлон оруулна.

Асуудал/Хэрэгцээ гэдэг нь Нийгэм, эдийн засаг, байгаль орчин, тэдгээрийн тодорхой бүлэг, хэсэгт тулгамдаж буй өөрчлөх шаардлагатай нөхцөл байдлыг илэрхийлэх нотолгоонд үндэслэсэн субъектив үнэлгээ юм. Асуудал нь шинж тэмдгээр дамжин илэрдэг. Жишээ нь: Халуурна гэдэг нь ямар нэг халдварт вирус, бактери эсвэл өөр хэд хэдэн хүчин зүйлээс үүдэлтэй эрүүл мэндийн асуудал байгааг илэрхийлэх шинж тэмдэг юм. Гол асуудлыг зөв тодорхойлох нь түүнийг шийдвэрлэх арга зам, үр дүнг оновчтой тодорхойлох суурь хүчин зүйл болно.

Багана 6: “Асуудал/хэрэгцээ, шалтгаан, уялдаа холбооны шинжилгээ” - ний үр дүнд тодорхойлсон асуудлын шууд шалтгааныг тодорхойлон оруулна. Асуудал буюу хэрэгцээ, шаардлагыг үүсгэж буй хүчин зүйлс нь **Шалтгаан** болно.

Шалтгаан: Асуудал буюу хэрэгцээ, шаардлагыг үүсгэж буй хүчин зүйлс нь нийгэм, эдийн засаг, байгаль орчинд тулгарч буй хүндрэл, бэрхшээл, асуудлыг үүсгэхэд дангаараа, эсхүл хамтран нөлөөлсөн байж болно. Ийм шалтгаалагч хүчин зүйлсийг арилгах, үр нөлөөг нь багасгах, бууруулахад хөтөлбөрийн үйл ажиллагаа чиглэгдэнэ.

Багана 7: ТЕЗ-ын асуудлын шалтгааныг арилгах стратегийг тодорхойлон бөглөнө. ТЕЗ-ийн хүрэх үр дүнг хангахын тулд ямар бодлогын нөлөөлөл хэрэгжүүлэх шаардлагатай вэ гэдгийг тогтоох замаар бодлогын түвшний стратеги тодорхойлогддог.

Стратеги: Урьдчилан төлөвлөсөн үр дүн болон үр нөлөөг бий болгоход чиглэсэн арга зам, эсхүл багц үйлдэл эсхүл санаачилгыг стратеги гэнэ. Стратеги нь урьдчилан төлөвлөсөн зорилго, үр дүнд хүрэхийн тулд хэрэгжүүлж буй хэд хэдэн үйл ажиллагаа болон үйл явцын цогц юм. Стратеги нь бодлогын болон хэрэгжилтийн түвшинд хамрах хүрээ, хугацааны хувьд ялгаатай байдлаар тодорхойлж болно.

Багана 8: ТЕЗ-ийн шийдвэрлэх асуудлыг эергээр тодорхойлох замаар буюу асуудлыг шийдвэрлэснээр хүрэх үр дүнг тодорхойлон харуулна.

Багана 9: Холбогдох ТХЗ-ыг оруулна.

Багана 10-15: ТЕЗ-ийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт, түүний суурь болон зорилтот түвшнийг тодорхойлон бөглөнө. Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад хувь нэмэр оруулж буйг илтгэн харуулах шалгуур үзүүлэлтийг багтаах шаардлагыг хангасан байна.

Суурь түвшин гэдэг хөтөлбөр хэрэгжиж эхлэх үеийн хөтөлбөрийн үр дүн, гарцын шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утга болно. Зорилтот түвшин гэж тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлт буюу үр дүнг хэмжихээр урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг хэлнэ.

Б. Төсвийн хөтөлбөрийн хүрэх үр дүн

Багана 16-17: Сангийн сайдын “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаас төсвийн зарлагын хөтөлбөрийн ангиллын тохирох кодыг оруулна.

Багана 18: Багана 6-г хуулан ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх асуудал гэж оруулна.

Багана 19: “Асуудал/хэрэгцээ, шалтгаан, уялдаа холбооны шинжилгээ”-ний үр дүнд тодорхойлсон ТЕЗ-ийн шийдвэрлэх асуудлын хоёрдогч шалтгааныг нь ТЕЗ-ийн хөтөлбөрийн асуудлын шалтгаан гэж оруулна.

Багана 20: ТЕЗ-ийн хөтөлбөрийн асуудлын шалтгааныг шийдвэрлэх арга зам буюу хөтөлбөрийн стратегийг тодорхойлон оруулна. Хөтөлбөрийг хэрхэн зүй зохистой, цагийг нь олж, бага зардлаар хэрэгжүүлэн хүссэн үр дүндээ хүрэх вэ? гэх асуултад хариулах байдлаар хөтөлбөрийн стратегийг тодорхойлно.

Багана 21: Багана 17-д оруулсан ТЕЗ-ийн хөтөлбөрийн асуудлыг эергээр тодорхойлох замаар буюу шийдвэрлэснээр бий болох хүрэх үр дүнг тодорхойлон оруулна.

Хөтөлбөрийн хүрэх үр дүн гэдэг нь тухайн хөтөлбөрийн үр шимийг хүртэгч зорилтот бүлгийн тулгамдсан асуудал, хэрэгцээ шаардлагыг хангахад гарах эерэг өөрчлөлт болно. Хөтөлбөрийн хүрэх үр дүнг ТЕЗ-ийн хүрэх үр дүнд шууд хувь нэмэр оруулахаар нягт уялдаатай тодорхойлно.

Багана 22-27: ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт, түүний суурь болон зорилтот түвшинг тус тус тодорхойлж оруулна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад хувь нэмэр оруулж буйг илтгэн харуулах хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг багтаах шаардлагыг хангасан байна.

Багана 28-29: ТЕЗ-ийн хөтөлбөрийн үр шим хүртэгчдийг зорилтот бүлэг болон хүйсийн ангиллын дагуу Багана 3-аас тодорхойлж оруулна.

Багана 30: ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн\гарцыг тодорхойлж оруулна.

Хөтөлбөрийн гарц (Output) гэдэг нь орцыг ашиглаж бий болгосон хэмжиж болохуйц эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээ юм. Гарц нь хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд бий болно.

Багана 31-36: ТЕЗ-ийн хөтөлбөрийн гарцын шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, түүний суурь болон зорилтот түвшинг тус тус тодорхойлон оруулна.

3. Ажлын хүснэгт2 бөглөх заавар - ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсвийн суурь тооцоо

3.1. ТЕЗ-ийн төсөв бэлтгэх

3.1.1 ТЕЗ-ийн хүрэх үр дүн, түүнийг хангахад чиглэсэн хөтөлбөрийн хүрэх үр дүнд суурилан хөтөлбөрийн төсвийн тооцоог доороос дээш буюу хөтөлбөрийн арга хэмжээний төсвийг нэгтгэн хөтөлбөрийн төсөв, хөтөлбөрийн төсвийг нэгтгэн ТЕЗ-ийн төсвийг тус тус тооцно.

3.1.2 СЯ-наас ирүүлсэн ТЕЗ-ийн зарлагын хязгаарыг баримтлан ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсвийн тооцоог хийнэ. ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн 2023-2025 оны төсвийн суурь тооцоог хийхэд ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсвийн суурь тооцооны ажлын хүснэгт 2 ашиглана.

3.1.3 ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр тус бүрээр хүрэх үр дүн, гарц, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, улмаар гарцын арга хэмжээг төлөвлөсний үндсэн дээр хөтөлбөрийн төсвийн суурь тооцоог нарийвчлан хийнэ. Хөтөлбөрийн арга хэмжээнд холбогдох хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамт тусгана.

3.1.4 Хөтөлбөрийн арга хэмжээний төсвийг зардлын эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллаар тооцно. Шаардлагатай орц (ажиллах хүн, шаардлагатай материал, г.м.), түүний хэмжих нэгж, нэгжийн өртөг, тоо хэмжээг тодорхойлно. Засгийн газрын тогтоолоор батлан мөрдөж буй салбарын хувьсах зардлын норм, нормативыг төсвийн тооцоонд баримтална. Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журам, 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд”-ыг ашиглан хөрөнгийн зардлыг тооцно.

3.1.5 ТЕЗ-ийн хүрэх үр дүнгийн стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийн стратегийн сонголт хийх зорилгоор хөтөлбөрийн хэрэгжилтийн стратегийн хувилбараар хөтөлбөрийн төсвийн тооцоог хийж болно. Энэ нь ТЕЗ-ийн хүрэх үр дүн, түүнийг хангахад чиглэсэн хөтөлбөр, түүний арга хэмжээний үндэслэл болно.

(Хөтөлбөрийн төсвийн суурь тооцооны ажлын хүснэгтийг хэрхэн бөглөхийг хөтөлбөрийн жишээгээр харуулав)

3.2 ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсвийн суурь тооцооны ажлын хүснэгт 2 бөглөх заавар

Багана 1- 2: “ТЕЗ-ын болон хөтөлбөрийн хүрэх үр дүнг тодорхойлох ажлын хүснэгт 1”-ийн багана 15 болон багана 29-ээс хөтөлбөрийн ангиллын код болон бүтээгдэхүүн\гарцыг хуулж тавина.

Багана 3-4: Бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тодорхойлон Сангийн сайдын “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаас хэрэгжүүлэх зориулалт, арга хэмжээний тохирох код, нэрийг сонгож оруулна.

Арга хэмжээ (activity) - Хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил үйлчилгээ юм.

Багана 5-6: Тодорхойлсон арга хэмжээний эхлэх, дуусах хугацааг оруулна.

Багана 7-12: Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн **ажилбарыг** тодорхойлж, түүнд шаардагдах орц, хэмжих нэгж, нэгжийн өртөг болон тоо хэмжээ, зардлыг тооцно.

Ажилбар (task) - хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр тодорхой журам, заавар, аргачлалын дагуу богино хугацаанд хийж гүйцэтгэх үйл ажиллагаа/үйлдэл юм.

Багана 13-14 Сангийн сайдын “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаас орц бүрийн зардлын тохирох эдийн засгийн ангиллын код, нэрийг оруулна.

ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн ажилбар, арга хэмжээний зардлыг нэгтгэн хөтөлбөрийн төсвийг тооцно. Хөтөлбөрийн төсвийг арга хэмжээний ангилал (арга хэмжээний эхлэх дуусах хугацааг үндэслэн нэг удаагийн шинжтэй, шинэ болон урт хугацааны шинжтэй)-аар мөн тооцон харуулна. Жишээлбэл, тухайн арга хэмжээ 2023 онд эхлээд тухайн онд хэрэгжиж дуусах бол нэг удаагийн шинжтэй, 2023 оноос хэрэгжиж эхлэх бол шинэ арга хэмжээ, он дамжин хэрэгжих арга хэмжээ бол урт хугацааны шинжтэй арга хэмжээ болно.

Нэг удаагийн шинжтэй арга хэмжээ - тухайн төсвийн жилд зөвхөн нэг удаа хэрэгжүүлэх арга хэмжээ болно

Шинээр хэрэгжих арга хэмжээ - хөтөлбөрийн болон гарцын хүрэх үр дүнг хангах зорилгоор хөтөлбөрийг өргөжүүлэх шинэ бодлого, арга хэмжээ төлөвлөж байгаа бол түүнийг шинэ арга хэмжээ гэж ангилна.

Урт хугацааны шинжтэй арга хэмжээ - хөтөлбөрийн болон түүний гарцын хүрэх үр дүнг хангах зорилгоор одоо хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашид үргэлжлэн хэрэгжих арга хэмжээ болно

ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр тус бүрийн төсвийг нэгтгэн ТЕЗ-ийн нийт төсвийг тооцно.